**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 10 өдөр Дугаар А/04 Хэрлэн сум

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, Эмнэлгийн тусламжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.30 дахь заалт, Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.2.20 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрүүл мэндийн сайдын 2020 оны "Журам батлах тухай" А/565 дугаар тушаалын дагуу зохион байгуулсан сонгон шалгаруулалтын дүн, хамт олны хурлын тэмдэглэл болон холбогдох байгууллагуудын Төлөөлөн удирдах зөвлөлд албан хаагчийг нэр дэвшүүлсэн шийдвэрүүдийг үндэслэн аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй батламжилсугай.

Өмчлөгчийн төлөөлөл:

| | |
|---|---|
| 1.Х.Дарханбаатар | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| 2.Л.Мэндбаяр | Эрүүл мэндийн газрын дарга |
| 3.Ч.Хэнчмэдэхгүй | Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга |

Эмнэлгийн хамт олны төлөөлөл:

| | |
|---|---|
| 1.Н.Отгонсүрэн | Нэгдсэн эмнэлгийн их эмч |
| 2.А.Дэлгэрмаа | Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албаны дарга |
| 3.Д.Урансайхан | Нэгдсэн эмнэлгийн хүний нөөцийн менежер |

Олон нийтийн төлөөлөл:

| | |
|---|---|
| 1.Д.Оюунбаяр | Монголын явган алхалтын холбооны гишүүн |
| 2.Д.Алтангэрэл | Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүн |

| | |
|---|---|
| 3.Р.Байгалмаа | 2.<br>Уламжлалт анагаах ухааны эмч,<br>судлаачдын нийгэмлэгийн гишүүн |

2.Холбогдох хууль, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хурлыг зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ